

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/20/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цогбаяр
Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn
Аудитор: Г.Өсөхжаргал
Утас: 51-261885 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn
Гроут финанс аудит ХХК-ийн захирал: Б.Бямбадорж
Утас: 88109366 Цахим хаяг: byambadorj@growthfinance.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ТБОНӨБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УТҮГ	Улсын төсвийн үйлдвэрийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.23 № 06/771
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Санхүүгийн мэдээллийн технологийн төв" УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Санхүүгийн мэдээллийн технологийн төв" УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр "Эмийн үнийн хяналтын систем"-ийг хөгжүүлэн нэвтрүүлэхтэй холбоотой 50.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, үүнээс үндсэн цалинд 30.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 8.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11.5 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 41, 550 дугаар тогтоолуудаар нийт 14.6 сая төгрөгийн хөрөнгийг Үйлдвэрлэл урлалын политехник коллежид балансаас балансад шилжүүлж, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 107.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасалт хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 үндсэн зорилтын хүрээнд 552 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилт 94.7 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49,674,747.05	84,779,101.55
33	АВЛАГА	3,459,419.98	3,712,000.00
335	Бусад авлага	3,459,419.98	3,712,000.00
3351	Байгууллагаас авах авлага	935,719.99	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,523,699.99	3,712,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	36,491,080.55
34600	Урьдчилж гарсан зардал	-	36,491,080.55
35	БАРАА МАТЕРИАЛ	46,215,327.07	44,576,021.00
354	Хангамжийн материал	46,215,327.07	44,576,021.00
35410	Бичиг хэргийн материал	4,818,259.43	3,146,502.43
35450	Аж ахуйн материал	38,144,267.64	38,510,018.57
35470	Бусад хангамжийн материал	3,252,800.00	2,919,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,187,109,781.97	1,015,264,011.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,187,109,781.97	1,015,264,011.76
392	Биет хөрөнгө	970,822,428.57	826,572,417.66
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,226,536,258.70	2,370,732,148.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,358,345,917.24)	(1,640,639,430.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,584,215.91	153,728,940.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(72,334,023.95)	(78,909,094.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	41,621,221.76	38,035,615.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,239,326.61)	(16,375,761.57)
393	Биет бус хөрөнгө	216,287,353.40	188,691,594.10
39301	Програм хангамж	272,177,373.00	272,177,373.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(55,890,019.60)	(83,485,778.90)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,519,250.00	10,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(11,519,250.00)	(10,000,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,236,784,529.02	1,100,043,113.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	26,280,000.00	5,610,057.64
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,280,000.00	5,610,057.64
413	Өглөг	26,280,000.00	5,610,057.64
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,809,806.00
4136	Бусад өглөг	26,280,000.00	3,800,251.64
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	26,280,000.00	3,800,251.64
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,210,504,529.02	1,094,433,055.67
51	Засгийн газрын хувь оролцоо	1,210,504,529.02	1,094,433,055.67
512	Хуримтлагдсан үр дүн	1,210,504,529.02	1,053,361,708.31
51210	Өмнөх үеийн үр дүн	1,298,585,720.18	1,210,504,529.02
51220	Тайлант үеийн үр дүн	(88,081,191.16)	(157,142,820.71)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	41,071,347.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,236,784,529.02	1,100,043,113.31

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,077,761,318.00	6,830,564,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	625,000.00	245,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	625,000.00	245,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	245,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	245,000.00
120009	Бусад орлого	525,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,077,136,318.00	6,830,319,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,029,568,300.00	6,780,319,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,029,568,300.00	6,780,319,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,568,018.00	50,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,568,018.00	50,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,164,068,118.79	6,973,075,864.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,164,068,118.79	6,973,075,864.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,905,614,124.54	6,972,430,814.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,420,341,784.99	4,536,644,997.97
210101	Үндсэн цалин	3,942,696,978.35	4,219,606,596.39
210102	Нэмэгдэл	145,769,237.59	165,447,677.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	147,259,322.51	151,590,723.92
210104	Урамшуулал	184,616,246.54	-
2102	Ажил олгогч төлөх нийгмийн даатгал	569,966,000.00	584,649,600.00
210201	Тэтгэврийн даатгал	403,576,900.00	409,897,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	41,597,300.00	43,687,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,798,600.00	21,844,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	20,798,600.00	21,844,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	83,194,600.00	87,375,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	356,455,803.76	559,131,466.00
210301	Гэрэл, цахилгаан	29,430,000.00	30,246,367.00
210302	Түлш, халаалт	6,110,956.14	7,113,633.37
210303	Цэвэр, бохир ус	-	2,443,745.63
210304	Байрны түрээс	320,914,847.62	519,327,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	357,315,487.69	8,909,605.04
210401	Бичиг хэрэг	4,916,002.66	7,241,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,342,145.25	1,668,305.04
210408	Бараа материал акталсны зардал	350,057,339.78	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,936,200.00	62,108,340.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,936,200.00	62,108,340.00
2107	Томилолт, зочны зардал	21,388,375.00	2,901,973.20
210701	Гадаад албан томилолт	14,633,575.00	2,901,973.20
210702	Дотоод албан томилолт	6,754,800.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	940,269,063.71	732,559,851.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	927,015,285.94	717,189,532.64
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,253,777.77	15,370,319.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	226,941,409.39	485,524,979.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,301,113.70	28,221,378.07
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	91,811,590.00	13,396,000.00

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,828,705.69	443,907,601.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	258,453,994.25	645,050.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,865,000.00	400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,865,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	129,588,994.25	245,050.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,588,994.25	245,050.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(86,306,800.79)	(142,510,964.93)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,774,390.37	14,631,855.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,774,390.37	14,631,855.78
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,774,390.37)	(14,631,855.78)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(88,081,191.16)	(157,142,820.71)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,077,761,318.00	6,830,564,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	625,000.00	245,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	625,000.00	245,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	245,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	245,000.00
120009	Бусад орлого	525,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,077,136,318.00	6,830,319,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,029,568,300.00	6,780,319,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,029,568,300.00	6,780,319,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,568,018.00	50,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,568,018.00	50,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,790,329,760.24	6,830,564,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,790,329,760.24	6,584,942,560.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,532,355,765.99	6,584,297,509.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,432,356,812.65	4,557,190,888.38
210101	Үндсэн цалин	3,954,712,006.01	4,240,152,486.80
210102	Нэмэгдэл	145,769,237.59	165,447,677.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	147,259,322.51	151,590,723.92
210104	Урамшуулал	184,616,246.54	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	569,966,000.00	584,649,600.00
210201	Тэтгэврийн даатгал	403,576,900.00	409,897,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	41,597,300.00	43,687,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,798,600.00	21,844,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	20,798,600.00	21,844,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	83,194,600.00	87,375,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	364,206,963.76	559,241,466.00
210301	Гэрэл, цахилгаан	29,430,000.00	30,246,367.00
210302	Түлш, халаалт	6,110,956.14	7,113,633.37
210303	Цэвэр, бохир ус	-	2,443,745.63

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210304	Байрны түрээс	328,666,007.62	519,437,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,636,795.25	3,334,405.04
210401	Бичиг хэрэг	3,294,650.00	1,666,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,342,145.25	1,668,305.04
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,392,600.00	65,060,740.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,392,600.00	65,060,740.00
2107	Томилолт, зочны зардал	21,388,375.00	2,901,973.20
210701	Гадаад албан томилолт	14,633,575.00	2,901,973.20
210702	Дотоод албан томилолт	6,754,800.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	959,304,767.33	780,527,014.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	944,623,377.06	762,864,449.16
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,681,390.27	17,662,565.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,103,452.00	31,391,422.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,499,862.00	17,995,422.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	96,603,590.00	13,396,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	257,973,994.25	645,050.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,385,000.00	400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,385,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	129,588,994.25	245,050.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,588,994.25	245,050.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	287,431,557.76	245,622,340.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	287,431,557.76	245,622,340.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	287,431,557.76	245,622,340.00
2200	Дотоод эх үүсвэрээр	287,431,557.76	245,622,340.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	287,431,557.76	245,622,340.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(287,431,557.76)	(245,622,340.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	1,298,585,720.18	1,298,585,720.18
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,298,585,720.18	1,298,585,720.18
Тайлант үеийн үр дүн	-	-	(88,081,191.16)	(88,081,191.16)
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	1,210,504,529.02	1,210,504,529.02
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,210,504,529.02	1,210,504,529.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	41,071,347.36	-	41,071,347.36
Тайлант үеийн үр дүн	-	-	(157,142,820.71)	(157,142,820.71)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	41,071,347.36	1,053,361,708.31	1,094,433,055.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,882,336,400.00	6,780,319,849.10	102,016,550.90	98.52
12	Татварын бус орлого	6,882,336,400.00	6,780,319,849.10	102,016,550.90	98.52
120	Нийтлэг татварын бус орлого	-	245,000.00	(245,000.00)	-
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	245,000.00	(245,000.00)	-
122	Тусламжийн орлого	6,882,336,400.00	6,780,074,849.10	102,261,550.90	98.51
122005	Төсвөөс санхүүжих	6,882,336,400.00	6,780,074,849.10	102,261,550.90	98.51
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,882,336,400.00	6,780,319,849.10	102,016,550.90	98.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,882,336,400.00	6,780,319,849.10	102,016,550.90	98.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,881,936,400.00	6,779,919,849.10	102,016,550.90	98.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,623,565,900.00	4,527,190,888.38	96,375,011.62	97.92
210101	Үндсэн цалин	4,252,101,500.00	4,210,152,486.80	41,949,013.20	99.01
210102	Нэмэгдэл	226,534,200.00	165,447,677.66	61,086,522.34	73.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	144,930,200.00	151,590,723.92	(6,660,523.92)	104.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	584,649,600.00	584,649,600.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	409,897,700.00	409,897,700.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	43,687,800.00	43,687,800.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,844,100.00	21,844,100.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	21,844,100.00	21,844,100.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	87,375,900.00	87,375,900.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	559,383,300.00	559,241,466.00	141,834.00	99.97
210301	Гэрэл, цахилгаан	30,372,400.00	30,246,367.00	126,033.00	99.59
210302	Түлш, халаалт	6,413,700.00	7,113,633.37	(699,933.37)	110.91

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	1,921,600.00	2,443,745.63	(522,145.63)	127.17
210304	Байрны түрээс	520,675,600.00	519,437,720.00	1,237,880.00	99.76
2104	Хангамж, бараа материалын зардал	4,289,400.00	3,334,405.04	954,994.96	77.74
210401	Бичиг хэрэг	1,667,700.00	1,666,100.00	1,600.00	99.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,621,700.00	1,668,305.04	953,394.96	63.63
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	287,332,200.00	287,106,080.00	226,120.00	99.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	287,332,200.00	287,106,080.00	226,120.00	99.92
2107	Томилолт, зочны зардал	2,902,000.00	2,901,973.20	26.80	100.00
210701	Гадаад албан томилолт	2,902,000.00	2,901,973.20	26.80	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	798,418,000.00	794,104,014.48	4,313,985.52	99.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	784,958,000.00	784,941,449.16	16,550.84	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,460,000.00	9,162,565.32	4,297,434.68	68.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,396,000.00	21,391,422.00	4,578.00	99.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,500,000.00	19,495,422.00	4,578.00	99.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,896,000.00	1,896,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,000.00	400,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	400,000.00	-	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	400,000.00	400,000.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	89	81	8	91.01
620001	Удирдах ажилтан	7	7	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	82	74	8	90.24
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	89	81	8	91.01
650013	Шатлалгүй цалин	89	81	8	91.01

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	50,000,000.00
12	Татварын бус орлого	-	50,000,000.00
122	Нийтлэг татварын бус орлого	-	50,000,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	50,000,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	50,000,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	50,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	50,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	50,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	50,000,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	30,000,000.00
210101	Үндсэн цалин	-	30,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	8,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	11,500,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын үндсэн зорилгоо “Монгол Улсын гааль, татвар, санхүүгийн мэдээллийн нэгдсэн системийн программ хангамжийн хөгжүүлэлт хийх, гааль, татвар, санхүүгийн албаны үйл ажиллагаанд мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдээллийн санг бий болгохтой холбоотой цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тус газрын дүрмийг Засгийн газрын 2024 оны 17 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, дүрэмд үйл ажиллагааны чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Санхүү, татвар, гаалийн байгууллагуудын захиалга, бодлогын даалгаврын дагуу мэдээллийн систем, программ хангамж хөгжүүлэх, тэдгээртэй уялдуулах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;
- Санхүү, татвар, гаалийн байгууллагын өгөгдлийн сангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, өгөгдөл боловсруулах, дүн шинжилгээ хийх;
- Санхүү, татвар, гаалийн үйл ажиллагааг цахимжуулах боломжийн талаар судалгаа, шинжилгээ хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- Хариуцсан мэдээллийн системийн сайжруулалт, хөгжүүлэлт, нэвтрүүлэлт, тасралтгүй үйл ажиллагааг хангах, техник, технологийн инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- Санхүү, татвар, гаалийн байгууллагын санхүүгийн мэдээллийн системийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшил нэвтрүүлж, аюулгүй байдлыг хангах;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн ажлын даалгавар, албан хүсэлтэд тусгагдсан асуудалд хамаарах үйл ажиллагааг цахимжуулахад мэдээллийн технологийн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;
- Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлогын хүрээнд төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хамтын ажиллагааг сайжруулж, цахим засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ нь үйл ажиллагаандаа Кибер аюулгүй байдлын тухай, Нийтийн ил тод байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлэд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлах тухай А/03 дугаар тушаал;
- Хууль зүй дотоод хэргийн сайдын 2025 оны А/100 дугаар тушаал “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”
- Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйл;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйл;

Тус газар нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс дотоод

аудитын үүрэг гүйцэтгэдэг байна. Тайлант хугацаанд дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Үйлдвэрийн газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын 16 арга хэмжээ авч хэрэгжүүлсэнд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын захирлын 2025 оны А/32 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 136.7 сая төгрөгөөр буюу 11.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өөрчлөлт	Хувь
Багана	1	2	3=2-1	4
Авлага	3.5	3.7	0.3	7.3%
Урьдчилж гарсан зардал, тооцоо	0.0	36.5	36.5	0.0%
Бараа материал	46.2	44.6	(1.6)	-3.5%
Үндсэн хөрөнгө	1,187.1	1,015.3	(171.8)	-14.5%
Нийт хөрөнгийн дүн	1,236.8	1,100.0	(136.7)	-11.1%
Өр төлбөр	26.3	5.6	(20.7)	-78.7%
Засгийн газрын хувь оролцоо	1,210.5	1,094.4	(116.1)	-9.6%
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,236.8	1,100.0	(136.7)	-11.1%

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Авлагын дансны үлдэгдэл нь 0.3 сая төгрөгөөр буюу 7.3 хувиар өсчээ. Ажилчдаас авах авлага 3.7 сая төгрөгийн дүн нь авлагыг бүрдүүлж байгаа бөгөөд завсрын аудитаар илрүүлсэн зөрчлийг залруулан бүртгэсэнтэй холбоотой үүсчээ.
- Урьдчилж гарсан зардал болон тооцооны үлдэгдэл болох 36.5 сая төгрөг нь аудитын залруулгын үр дүнд үүссэн болно. Уг дүн нь 1 жилийн хугацаанд ашиглагдах программын лицензийн төлбөрт хамаарах тул дараагийн тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрсөн дүн юм.
- Бараа материал дансны үлдэгдэл нь 44.6 сая төгрөг болж өмнөх оноос 1.6 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар буурчээ. Бараа материалын үлдэгдлийн 86.4 хувийг аж ахуйн материал бүрдүүлж байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1,015.3 сая төгрөг болж, өмнөх оноос 171.8 сая төгрөгөөр буюу 14.5 хувиар буурсан нь тайлант онд 245.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг 41.1 сая төгрөгөөр дахин үнэлсэн, нийт 286.7 сая төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 41, 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 550 тоот дугаар тогтоолуудаар 14.6 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн, 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А-1/2134 дугаар бүхий албан бичгээр элэгдлээрээ өртгөө нөхсөн 107.5 сая төгрөгийн хөрөнгүүдийг акталж, элэгдлийн зардалд 443.9 сая төгрөг тооцонтой тус тус холбоотой байна.
- Өр төлбөр өмнөх үлдэгдлээс 20.7 сая төгрөгөөр буюу 78.7 хувиар буурчээ. Өр төлбөрийн үлэгдэл нь ХХОАТ-ын өр 3.8 сая төгрөг, ажиллагсад өгөх өглөг 1.8 сая төгрөгөөс бүрдэж байна.
- Засгийн газрын хувь оролцооны дүн 116.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдал 157.1 сая төгрөгөөр буурч үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 41.1 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад 282.2 сая төгрөгийн анхны өртөг бүхий 2 программ бүртгэлтэй байгаагаас 0.8 сая төгрөгийн “Й Би Ай” ХХК-ийн Emerald санхүүгийн программыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 7,198.8 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналын дагуу 7,198.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд тайлант оны 6 дугаар сард улсын төсөвт нэг удаа тодотгол хийж, батлагдсан төсвийг 316.5 сая төгрөгөөр бууруулан 6,882.3 сая төгрөгөөр шинэчлэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,780.1 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 0.2 сая төгрөг бүрдүүлж, 6,780.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,780.3 сая төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 96.4 сая төгрөг, тогтмол зардал 0.1 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 1.0 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 0.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 4.3 сая төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр	Арга хэмжээний		2025 он		/сая төгрөгөөр/ Зөрүү	
	Код	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
70205 Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,097.0	5,995.0	0.1	98.3
	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	741.2	741.2	0.0	100.0
	80220	Холбооны суваг ашигласны хөлс	43.8	43.8	0.02	100.0
	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	0.4	0.4	0.0	100.0
Нийт дүн			6,882.3	6,780.3	102.0	98.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

1. Сангийн сайдын 2025 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 152 дугаар тушаалаар 89 орон тоотой ажиллахаар баталжээ. Тус газрын хариуцан ажилладаг 34 системийн 1 хүнд ногдох системийн тоо харьцангуй өндөр, ачаалал ихтэй байдаг. Иймд уг тушаалаар системийн хөгжүүлэгч 2, систем хяналтын мэргэжилтэн 4, системийн бааз хариуцсан мэргэжилтэн 2, сүлжээний мэргэжилтэн 3, нийт 11 орон тоогоор нэмэгдсэн. 2025 онд уг батлагдсан орон тоонд хүргэж хүн нэмж аваагүй бөгөөд 81 хүний орон тоотойгоор ажилласан. Тус байгууллагад орон тооны цомхотгол хийгдээгүй.
2. Тус байгууллагын захиралын 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн А/13 тоот тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоот журамд хоолны хөнгөлөлтийг 1 өдрийн 7,000 төгрөгөөр унааны хөнгөлөлт 1 өдрийн 3,000 төгрөгөөр тус тус тооцож олгохоор баталжээ. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд 144.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 151.6 сая төгрөгийг олгож, батлагдсан төсвийг 6.7 сая төгрөгөөр илүү зарцуулжээ. Энэ нь төсөвт тодотгох үед хоол, унааны хөнгөлөлтийн дүнг бууруулан тусгасантай холбоотойгоор үүссэн болно.
3. Тайлант онд тухайн байгууллага нь гадаад томилолт, гадаад зочин хүлээн авах арга хэмжээ зэрэгт зардал төсөвлөөгүй ба гүйцэтгэлээр зарцуулалт хийгдээгүй байна.

4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн, түүнтэй адилтгах арга хэмжээнд зардал төсөвлөөгүй ба гүйцэтгэлээр зарцуулалт хийгдээгүй байна.
5. 2025 онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, төлбөр төлөөгүй.
6. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотойгоор гарсан зардал, зарцуулалт байхгүй.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ДЭМБ-ын санхүүжилтээр “Эмийн үнийн хяналтын систем”-ийг хөгжүүлэн нэвтрүүлэхтэй холбоотой 50.0 сая төгрөгийн санхүүжилт орж, үүнээс үндсэн цалинд 30.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 8.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Санхүүгийн мэдээлэл технологийн төв УТҮГ нь 2025 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд тус байгууллага нь 1,726.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, үүнээс 981.2 сая төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Нийт худалдан авалтаас 429.6 сая төгрөгийн худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, 551.6 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээнүүдийг харьцуулалтын аргаар шууд худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн ТӨҮГ-ын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зардлыг зөв төлөвлөн, төвлөсөн ангиллыг ангиллын дагуу тусгах, өр төлбөр үүсгэхгүйгээр төлөвлөж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Гроут финан Аудит” ХХК-ийн аудитор Э.Нарангэрэл, С.Баяртогтох, Б.Хонгорзул нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Ч.Хүнбиш, гүйцэтгэх захирал Б.Бямбадорж нар хэрэгжүүлж, үе шатны хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Өсөхжаргал, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

“Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01/21 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардал 7,164.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 71.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 102.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласнаас төлөвлөсөн 89 орон тооноос 8 орон тоогоор дутуу ажиллаж, цалингийн зардлаас 96.4 сая төгрөгийн бодит хэмнэлт гаргасан байна .

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Тус компани нь нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 154 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, холбогдох данстын хувьд горим, сорил хэрэгжүүлж, 47.5 сая төгрөгийн 2 алдаа, 7.6 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 37.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, 20.8 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	2	37.6	2	37.6	100.0
Зөвлөмж	2	20.8	2	20.8	100.0
Нийт дүн	4	58.4	4	58.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарлаа хандуулж аудитын горим, сорилыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал:

- Нэг жилийн хугацаатай программын төлбөрийг хугацаанд нь тохируулан аккрузал сууриар бүртгэж байгаа эсэхийг шалгах.
- Үйл ажиллагаа, системийн аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх программууд, эдгээрийн лицензийн төлбөрийг батлагдсан төсвөөс хэтрүүлэн худалдан авалт хийсэн эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Нэг жилийн хугацаатай лицензийн зардлыг хугацаагаар нь хуваарилж бүртгээгүй тайлант онд бөөн дүнгээр нь зардлаар хүлээн зөвшөөрч, 2026 оны зардлаар хүлээн зөвшөөрөх дүнг урьдчилан тооцоогүй, урьдчилж төлсөн зардлаар тайлагнаагүй.

Энэ нь УСНББОС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал 27, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 10.0 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 10.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Тус газрын захирлын 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А/27 дугаар тушаалаар 4 хүний 6.2 сая төгрөгийн томилолтын зардлыг гаргасан боловч бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж дансанд буруу ангилан бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д "Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг холбогдох заавар журмын дагуу ангиллыг үнэн зөв бүртгэж тайлагнаж байх.

2.Татвартай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Ажилтнуудын цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан хувь хүний орлогын албан татвар 3.8 сая төгрөгийг тайлант хугацаанд төлөөгүй, өр төлбөр үүсгэсэн.

Энэ нь Хувь хүний орлогийн албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг хэрэгжүүлэн ажиллах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалин хөлснөөс суутгасан албан татварыг хуульд заасан хугацаанд тухай бүр төсөвт бүрэн шилжүүлэх, өр төлбөр үүсгэхгүй байх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардлыг тайлант оны хугацаагаар нь хуваарилж бүртгээгүй бөөн дүнгээр нь зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан.	1	36.5			1	36.5	1	36.5		
Нийт дүн	1	36.5	-	-	1	36.5	1	36.5	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотоод албан томилолтын зардлыг буруу ангилан бүртгэсэн.	1	6.2	-	-	-	-	1	6.2
Ажилчдын цалин хөлснөөс суутгасан ХХОАТ-ыг хугацаанд нь төлөөгүйгээс өр төлбөр үүссэн байна.	1	3.8	-	-	-	-	1	3.8
Дүн	2	10.0	-	-	-	-	2	10.0